БӨӨР ХАМГААЛАХ ҮЙЛДЭЛТЭЙ НИЙЛМЭЛ БЭЛДМЭЛИЙН ФИТОХИМИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Б.Пэрлэйдулам[1], Г.Энхмаа[2], И.Энхцог[2], Ц.Чимгээ[2], Ч.Ерөөлт[2]

[1]АШУҮИС, Эм зүйн сургууль
[2]АШУҮИС, БАС, Эм судлалын тэнхим

Түлхүүр үгс:
Цинарин, аскорбины хүчил, нийлбэр флавоноид, Сөөгөн боролзгоно, Өргөст нохой хошуу, Артишок

Товч утга: Аливаа өвчний эмчилгээнд зөвхөн байгалийн цэвэр нэгдлээс гадна эмийн ургамлын идэвхтэй бодис өндөр агуулсан хандыг ургамлын гаралтай эмээр бүртгэж хэрэглэдэг ба энэ нь бие махбодын ерөнхий байдлыг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хурц болон архаг өвчнийг эмчлэх үйлдэлтэй байдаг бөгөөд хандад агуулагдаж буй олон бодис нь эс, молекулын төвшинд бие биенээ дэмжих эсвэл үгүйсгэх зэрэг үйлдлийг үзүүлдэг буюу олон байд зэрэг үйлчилдэг тул эмчилгээний идэвхтэй, мөн хорон чанар багатай байдаг. Бид Монгол оронд ургадаг, уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгдэж ирсэн бөөр хамгаалах үйлдэлтэй зарим ургамлыг сонгон авч шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж цаашид фармакологийн идэвхтэй үйлдэлтэй, аюулгүй, гаж нөлөө багатай эмийн бэлдмэл гарган авах зорилго тавин ажиллаж байна. Сөөгөн боролзгоно, Өргөст нохой хошуу, Артишок зэрэг ургамлын түүхий эдээс идээшмэл болон 20%, 40%, 70%-ийн этанолын ханд гарган авч тус бүрийн ба нийлмэл хандын фармакологийн үйлдэл үзүүлж буй гол биологийн идэвхт бодисын агууламжийг тодорхойллоо. Сөөгөн боролзгоны *(Dasiphora fruticosa L.)* цэцгийн 70%-н этанолын хандад нийлбэр флавоноидын агууламж, Өргөст нохойн хошуу *(Rosa acicularis L)*-ны үр жимсний идээшмэлд аскорбины хүчлийн агууламж, Артишок *(Cynara scolymus L.)*-н өвсний 70%-н этанолын хандад цинарины агууламж нь идээшмэл болон бусад этанолын хандаас өндөр байсан тул цаашид нийлмэл ханд гарган авахдаа биологийн идэвхт бодисын агууламж өндөр ханд болон идээшмэлийг сонгон авах дүгнэлтэд хүрэв.

Үндэслэл: Орчин үед байгалийн бүтээгдэхүүн болох эмийн ургамлуудаас төрөл бүрийн өвчнийг анагаах чадалтай биологийн идэвхт бодисуудыг таньж тодорхойлон, ялган авч фармакологийн үйлдлийг нь тогтоон анагаах ухаан болон хүнсний биологийн идэвхт нэмэлт бүтээгдэхүүнд өргөн хэрэглэж байгаа өнөө үед судлаач бидний өмнө Монгол орныхоо эмийн ургамлуудыг судлан орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар өгөх томоохон зорилт тавигдаж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар нийт хүн амын ялангуяа хөгжиж буй орны хувьд 70-80% нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээндээ уламжлалт анагаах ухаан, тэр дундаа ургамлын гаралтай эмийн бэлдмэл хэрэглэх хандлагатай байдгийг тогтоожээ[1].

Дэлхий дахинд бөөрний цочмог болон архаг эмгэгтэй өвчтөний тоо жил тутам өсч байгаа бөгөөд энэ нь хүн амын хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байна. Монгол улсын ЭМЯ-наас гаргасан сүүлийн 5 жилийн судалгаагаар халдварт бус өвчлөлийн дотор бөөр, шээсний замын өвчлөл нь тархалтаараа 4-рт орж байгаа [2] зэрэг нь Монгол оронд ургадаг, уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгдэж ирсэн бөөр хамгаалах үйлдэлтэй зарим ургамлыг сонгон авч шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, цаашид өндөр идэвхтэй чанартай, аюулгүй эмийн бэлдмэл гарган авах нь судалгааны ажил хийх үндэслэл болж байна.

Зорилго: Бөөр хамгаалах үйлдэлтэй зарим ургамлын идээшмэл болон спиртэн хандад агуулагдах биологийн идэвхт бодисын хэмжээг тодорхойлох

Зорилт:

1. Өргөст нохойн хошууны (*Rosa acicularis* L.) үр жимсний идээшмэл болон этанолын хандад агуулагдах аскорбины хүчлийн хэмжээг тодорхойлох
2. Сөөгөн боролзгоны (*Dasiphora fruticos*a L). цэцгийн идээшмэл болон этанолын хандад агуулагдах нийлбэр флавоноидын хэмжээг тодорхойлох
3. Артишокийн *(Cynara scolymus L)*. өвсний идээшмэл болон этанолын хандад агуулагдах цинарины хэмжээг тодорхойлох
4. Эдгээр ургамлаас бэлдсэн нийлбэр хандад